ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

## Халзан-Уул рашаан сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/20/СТА-ТШЗ

---

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд

2020 он


Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn

Аудитор: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

**Аудитын гэрчилгээ** ........ 3
Аудитын тайлан ........ 5
2.1. Оршил ........ 5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 9
2.13. Шилэн дансны мэдээлэл ........ 9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ........ 9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 9
Менежментийн захидал ........ 10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ........ 11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ........ 11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........

## Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.13 №1-6/59

танай__________-ны №__________-т

ХАЛЗАН УУЛ РАШААН СУВИЛЛЫН
ДАРГА П.ЭРДЭНЭЦЭЦЭГ
ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халзан уул рашаан сувиллын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Халзан уул рашаан сувиллын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Халзан уул рашаан сувиллын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020028

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

## 2.1. Оршил

Халзан-Уул рашаан сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Д.Эрдэнэцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халзан уул рашаан сувиллын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

.Халзан уул рашаан сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 29-ээс 2020 оны 01 дугаар сарын 30–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 дугаар сарын 31-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Халзан уул рашаан сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Халзан уул рашаан сувиллын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Үйлчлүүлэгчээ дээдлэн чанар нөөц нь тогтоогдсон , рашаан ус, байгалийн бусад нөөц, өрнө, дорнын анагаах ухааны дэвшилтэт аргыг хослуулан сэргээн засах, асрах, сувилах тусламж үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлэхэд оршино.

. Халзан уул рашаан сувиллын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сувилахуйн дагнасан тусламж үйлчилгээ
- Сэргээн засах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЭМС-ын 382-р тушаал

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Халзан уул рашаан сувиллын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Халзан уул рашаан сувилал нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд acolous программ хангамж ашигладаг байна.

Халзан уул рашаан сувиллын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Халзан уул рашаан сувиллын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 437,399.5 мянган төгрөгөөс тооцон 4,373.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 4281.5 мянган төгрөгөөр тооцсон нь жилийн эцсийн тайлангийн цэвэр хөрөнгө тайлант онд 7244.0 мянган төгрөгийг алдагдлаас шалтгаалан цэвэр хөрөнгө буурсантай холбоотой болно.

### 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Халзан уул рашаан сувиллын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25540.6 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 525.5 | 866.5 | 341.0 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 38,804.3 | 49,643.3 | 10,839.0 |
| Үндсэн хөрөнгө | 396,064.9 | 377,641.2 | -18,423,7 |
| **Нийт хөрөнгө** | 435,395.1 | 428,151.1 | 7,244.0 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 435,395.1 | 428,151.1 | 7,244.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 435,395.1 | 428,151.1 | 7,244.0 |

2019 онд 720 хүнд үйлчилнэ гэж төлөвлөсөн боловч 380 хүнд үйлчилсэн бөгөөд нийт төсөв өмнө оноос 62495.8 мянган төгрөгөөр нэмж баталсан. Үүнээс бараа материалын зардал болох тээвэр шатахууны зардал 2072.6 мянган төгрөг, эм, эмнэлгийн хэрэгсэл 500.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал 3000.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардал 5000.0 мянган төгрөг хог хаягдал, хортон мэрэгчдийг устгах зардал 1699.9 мянган төгрөгөөр, багаж техник хэрэгсэл 39179.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагдсан бөгөөд үйлчлүүлэгчийн тоо төлөвлөгөөндөө хүрээгүйн улмаас бараа материалын үлдэгдэл 10839.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Жилийн эцэст 1 сарын хэрэгцээтэй тэнцэх хэмжээний 2235.0 мянган төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй байна.

Энэ нь тайлант онд төлөвлөгөө 2072.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн мөн сувилуулагч бага байснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө нь 25540.6 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авч тайлант онд 43964.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулж нийт 18423.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгөөс үнэ төлбөргүй шилжүүлсэн, акталсан хөрөнгө байхгүй байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 428,151.1 мянган төгрөг болж 7244.0 мянган төгрөгөөр буурсан нь 2019 онд 7244.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласнаас шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Халзан уул рашаан сувилал нь тайлант онд 254,558.8 мянган төгрөгийн санхүүжилттэй байхаар батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 231,863.3 мянган төгрөгийн санхүүжилт орж 91.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Хүснэгт 2. Санхүүжилтийн* орлого . /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Улсын төсвөөс санхүүжих | 95,058.8 | 95,058.8 | 0.0 | 100 |
| ЭМД-аас санхүүжих | 41,500.0 | 40,700.0 | 800.0 | 98.1 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,000.0 | 88,440.0 | 21,895.5 | 88.4 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18,000.0 | 7,651.6 | 10,348.4 | 42.6 |
| **Нийт дүн** | 254,558.8 | 231,850.8 | 22,708.0 | 91.1 |

ЭМД-аас санхүүжих орлого 800.0 мянган төгрөгөөр Үндсэн үйл ажиллагааны орлого 21,895.5 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлого 10,348.4 мянган төгрөгөөр тус тус санхүүжилт дутуу орсон байна. 2019 онд үйл ажиллагаа явуулдаг Даланжаргалан суманд малын шүлхий өвчин гарснаас үйлчлүүлэгчийн тоо багассантай холбоотой

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрт зориулан 254,558.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 231,863.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 95058.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 41500.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 118,000.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан товч тайлбарлавал

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 231,863.3 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байна. Цалин хөлс 814.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,887.9 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 19,847.9 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

### 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 9390.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 6667.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 2723.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

### 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Малыг зах зээлийн үнээс хэт бага үнээр үнэлж бүртгэсэн байна.

### 2.12. Шилэн дансны мэдээлэл

Халзан уул рашаан сувиллын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 141 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт албан шаардлага, зөвлөмж байхгүй

### 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Халзан уул рашаан сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Халзан уул рашаан сувиллын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт: Цалингийн зардлаас 123.2 мянган төгрөгийг томилолтын зардалд, хог хаягдал хортон шавьж устгах зардлаас 2599.9 мянган төгрөгийн үнэтэй кондэйшн худалдан авсан*

1.2. *Эрсдэл: Батлагдсан төсөв хэтрэх, зориулалтын зардалд хүрэхгүй байх*

1.3. *Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалд заасны дагуу зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зориулалтын зарцуулж байх*

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрсөн*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **39,330,098.17** | **50,510,146.66** |
| **33** | **АВЛАГА** | 525,751.60 | 866,801.44 |
| **335** | **Бусад авлага** | 525,751.60 | 866,801.44 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 498,751.60 | 866,801.44 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 27,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 38,804,346.57 | 49,643,345.22 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,493,571.00 | 3,174,594.20 |
| 35130 | Эм боох материал | 2,493,571.00 | 3,174,594.20 |
| **354** | **Хангамжийн материал** | 34,767,775.57 | 44,876,751.02 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 926,126.00 | 906,136.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 26,924,747.40 | 34,290,345.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 6,008,100.00 | 4,641,100.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 18,662.00 | 2,235,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 510,970.00 | 510,970.00 |
| 35460 | Хүнсний материал | 379,170.17 | 2,293,200.02 |
| 35600 | Мал амьтад | 1,543,000.00 | 1,592,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **396,064,973.89** | **377,641,205.16** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 396,064,973.89 | 377,641,205.16 |
| **392** | **Биет хөрөнгө** | 359,346,973.89 | 340,923,205.16 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 195,793,538.95 | 195,793,538.95 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -12,693,238.80 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 52,051,250.00 | 52,051,250.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -15,028,854.66 | -23,178,854.70 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 23,394,820.00 | 38,486,456.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -18,377,539.44 | -22,798,898.19 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 27,701,990.00 | 38,150,990.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -23,691,554.95 | -25,375,808.49 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 255,915,587.00 | 255,915,587.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -138,440,263.01 | -155,455,816.61 |
| 39217 | Ном | 28,000.00 | 28,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 36,718,000.00 | 36,718,000.00 |
| 39301 | Програм хангамж | 400,000.00 | 400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -400,000.00 | -400,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 36,718,000.00 | 36,718,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **435,395,072.06** | **428,151,351.82** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **435,395,072.06** | **428,151,351.82** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 435,395,072.06 | 428,151,351.82 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 391,404,042.32 | 391,404,042.32 |
| 51101 | Өмч: - төрийн | 391,404,042.32 | 391,404,042.32 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -78,649,812.37 | -85,893,532.61 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -78,649,812.37 | -78,649,812.37 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -7,243,720.24 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 122,640,842.11 | 122,640,842.11 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **435,395,072.06** | **428,151,351.82** |

## 1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **267,850,469.00** | **235,240,080.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **196,369,269.00** | **99,481,280.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 196,369,269.00 | 99,481,280.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 196,369,269.00 | 99,481,280.00 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 81,713,000.00 | 88,440,410.00 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,492,200.00 | 1,617,620.00 |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 105,164,069.00 | 9,423,250.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **71,481,200.00** | **135,758,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 28,361,200.00 | 95,058,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 28,361,200.00 | 95,058,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 43,120,000.00 | 40,700,000.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 43,120,000.00 | 40,700,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **187,557,141.63** | **242,483,800.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **187,557,141.63** | **242,483,800.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 187,011,164.69 | 241,423,701.70 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 66,345,171.90 | 97,012,756.75 |
| 210101 | Үндсэн цалин | 59,480,760.90 | 88,448,806.75 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,659,953.00 | 4,941,000.00 |
| 210104 | Урамшуулал | 4,726,612.00 | 3,622,950.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 477,846.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 10,356,601.00 | 14,667,651.04 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,826,897.00 | 10,024,356.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 382,426.00 | 1,131,123.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 305,941.00 | 748,867.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 76,485.00 | 292,237.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 764,852.00 | 2,471,065.66 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,049,351.00 | 4,612,019.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,049,351.00 | 4,612,019.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,585,636.20 | 22,972,576.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,237,600.00 | 2,078,590.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,245,824.20 | 7,639,989.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 156,420.00 | 173,020.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 420,000.00 | 25,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,134,797.00 | 00.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | -1,595,143.00 | 13,055,977.40 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,986,138.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 21,234,472.33 | 22,817,530.95 |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 536,150.00 | 1,265,197.80 |
| 210502 | Хоол, хүнс | 20,698,322.33 | 21,552,333.15 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,564,781.20 | 7,729,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,564,781.20 | 7,721,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 320,550.00 | 422,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 320,550.00 | 422,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 32,483,855.36 | 26,334,262.83 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 32,165,645.36 | 25,829,510.83 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 216,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 78,210.00 | 131,252.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 157,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29,070,745.70 | 44,854,404.73 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 478,000.00 | 890,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 28,592,745.70 | 43,964,404.73 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 545,976.94 | 1,060,098.54 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 470,000.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 470,000.00 | 200,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 75,976.94 | 860,098.54 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 75,976.94 | 860,098.54 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **80,293,327.37** | **-7,243,720.24** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **80,293,327.37** | **-7,243,720.24** |

## 1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **167,687,000.00** | **231,850,830.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **96,205,800.00** | **96,092,030.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 96,205,800.00 | 96,092,030.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 96,205,800.00 | 96,092,030.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 81,713,000.00 | 88,440,410.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,492,800.00 | 7,651,620.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **71,481,200.00** | **135,758,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 28,361,200.00 | 95,058,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 28,361,200.00 | 95,058,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 43,120,000.00 | 40,700,000.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 43,120,000.00 | 40,700,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **167,687,000.00** | **206,310,194.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **167,687,000.00** | **206,310,194.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **167,044,444.06** | **205,250,095.46** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 65,824,820.30 | 97,012,756.75 |
| 210101 | Үндсэн цалин | 58,960,409.30 | 88,448,806.75 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,659,953.00 | 4,941,000.00 |
| 210104 | Урамшуулал | 4,726,612.00 | 3,622,950.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 477,846.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 10,356,601.00 | 14,667,651.04 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,826,897.00 | 10,024,356.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 382,426.00 | 1,131,123.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 305,941.00 | 748,867.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 76,485.00 | 292,237.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 764,852.00 | 2,471,065.66 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,593,351.00 | 4,999,519.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,049,351.00 | 4,612,019.00 |
| 210302 | Түлш, халаалт | 544,000.00 | 387,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,044,506.00 | 18,786,573.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,289,550.00 | 1,240,525.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,549,300.00 | 9,856,327.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 618,570.00 | 328,020.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 476,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 420,000.00 | 75,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,167,086.00 | 6,810,001.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 22,570,877.90 | 27,992,637.44 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,293,025.00 | 1,943,981.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,859,192.90 | 20,437,206.44 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 418,660.00 | 5,611,450.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,694,535.50 | 12,893,610.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,473,715.00 | 3,175,720.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 1,438,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 87,300.00 | 364,320.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,133,520.50 | 7,915,570.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 320,550.00 | 422,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 320,550.00 | 422,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 33,639,202.36 | 28,474,748.23 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 33,320,992.36 | 27,969,996.23 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 216,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 78,210.00 | 131,252.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 157,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **642,555.94** | **1,060,098.54** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 566,579.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 566,579.00 | 200,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 75,976.94 | 860,098.54 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 75,976.94 | 860,098.54 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **25,540,636.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **25,540,636.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **25,540,636.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 25,540,636.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 25,540,636.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-25,540,636.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 391,404,042.32 | 23,830,943.86 | -145,525,680.91 | 269,709,305.27 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **391,404,042.32** | **23,830,943.86** | **-145,525,680.91** | 269,709,305.27 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 80,293,327.37 | 80,293,327.37 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **391,404,042.32** | **122,640,842.11** | **-78,649,812.37** | 435,395,072.06 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **391,404,042.32** | **122,640,842.11** | **-78,649,812.37** | 435,395,072.06 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **391,404,042.32** | **122,640,842.11** | **-78,649,812.37** | 435,395,072.06 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -7,243,720.24 | -7,243,720.24 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **391,404,042.32** | **122,640,842.11** | **-85,893,532.61** | 428,151,351.82 |

## 1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 254,558,800.00 | 231,863,330.00 | 22,695,470.0 | 91.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 254,558,800.00 | 231,863,330.00 | 22,695,470.0 | 91.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 254,318,800.00 | 230,803,231.46 | 23,515,568.5 | 90.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 97,950,000.00 | 97,135,956.75 | 814,043.3 | 99.2 |
| 210101 | Үндсэн цалин | 82,550,000.00 | 88,572,006.75 | -6,022,006.8 | 107.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,500,000.00 | 4,941,000.00 | 2,559,000.0 | 65.9 |
| 210104 | Урамшуулал | 7,900,000.00 | 3,622,950.00 | 4,277,050.0 | 45.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,779,300.00 | 14,667,651.04 | 3,111,649.0 | 82.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,089,900.00 | 10,024,356.72 | 2,065,543.3 | 82.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,422,300.00 | 1,131,123.33 | 291,176.7 | 79.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,137,900.00 | 748,867.66 | 389,032.3 | 65.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 284,500.00 | 292,237.67 | -7,737.7 | 102.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,844,700.00 | 2,471,065.66 | 373,634.3 | 86.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 6,887,500.00 | 4,999,519.00 | 1,887,981.0 | 72.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,500,000.00 | 4,612,019.00 | -112,019.0 | 102.5 |
| 210302 | Түлш, халаалт | 2,387,500.00 | 387,500.00 | 2,000,000.0 | 16.2 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,432,800.00 | 21,432,473.00 | 327.0 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 990,000.00 | 1,240,525.00 | -250,525.0 | 125.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,487,600.00 | 9,856,327.00 | 631,273.0 | 94.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 400,000.00 | 328,020.00 | 71,980.0 | 82.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 476,700.00 | -476,700.0 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,674,900.00 | 2,674,900.00 | 0.0 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,880,300.00 | 6,856,001.00 | 24,299.0 | 99.6 |
| **2105** | **Нормативт зардал** | 27,997,400.00 | 27,992,637.44 | 4,762.6 | 100.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,980,000.00 | 1,943,981.00 | 36,019.0 | 98.2 |
| 210502 | Хоол, хүнс | 18,943,500.00 | 20,437,206.44 | -1,493,706.4 | 107.9 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,073,900.00 | 5,611,450.00 | 1,462,450.0 | 79.3 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 55,295,300.00 | 35,447,346.00 | 19,847,954.0 | 64.1 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 44,011,000.00 | 21,260,056.00 | 22,750,944.0 | 48.3 |
| 210602 | Тавилга | 3,000,000.00 | 5,907,400.00 | -2,907,400.0 | 196.9 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 364,300.00 | 364,320.00 | -20.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 7,920,000.00 | 7,915,570.00 | 4,430.0 | 99.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 300,000.00 | 299,400.00 | 600.0 | 99.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 300,000.00 | 299,400.00 | 600.0 | 99.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 26,676,500.00 | 28,828,248.23 | -2,151,748.2 | 108.1 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,140,500.00 | 28,310,996.23 | -2,170,496.2 | 108.3 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 216,000.00 | 216,000.00 | 0.0 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 131,252.00 | -131,252.0 | |
| 210807 | Газрын төлбөр | 150,000.00 | 00.00 | 150,000.0 | 0.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 170,000.00 | 170,000.00 | 0.0 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 240000.00 | 200000.00 | 40,000.0 | 83.3 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 240,000.00 | 200,000.00 | 40,000.0 | 83.3 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 240,000.00 | 200,000.00 | 40,000.0 | 83.3 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 254,558,800.00 | 231,850,830.00 | 22,707,970.0 | 91.1 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 95,058,800.00 | 95,058,800.00 | 0.0 | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 95,058,800.00 | 95,058,800.00 | 0.0 | 100.0 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 41,500,000.00 | 40,700,000.00 | 800,000.0 | 98.1 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 41,500,000.00 | 40,700,000.00 | 800,000.0 | 98.1 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 118,000,000.00 | 96,092,030.00 | 21,907,970.0 | 81.4 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,000,000.00 | 88,440,410.00 | 11,559,590.0 | 88.4 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18,000,000.00 | 7,651,620.00 | 10,348,380.0 | 42.6 |